

## Таван зүйлийн тарианд холбогдох соёл, монголчуудын үнэт зүйл болох нь

Батгоморийн Хоролсүрэн 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ horloo.0216@gmail.com

**Хураангуй:** Монгол нутагт хүн үүсэж, амьдарч эхэлсэн үеэс байгалийн жимс жимсгэнэ, зэрлэг үр тариа, сонгино, мөөг, гогод, эмийн ургамал зэрэг бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэж байгаад, хөгжлийн тодорхой шатанд тэдгээрийг амталж, болгож, хольж, боловсруулж хэрэглэх үйл явцад шилжсэнээр идээ, ундааны соёл бий болжээ.

Хүн байгалийн тайлагдашгүй элдэв үзэгдэл, сүр хүчинд автахдаа, түүний цаана ямар нэгэн хүч чадалт далдын эзэн бий хэмээн үзэж хүншүүлэх, амьшуулах, юмшуулах зэрэг дүрийг бий болгон сүсэглэж, тэдгээрийг аргадах, гуйх, тайтгаруулах, залбирах зэргээс үүдэн янз бүрийн зан үйлүүд үүсжээ. Дээрх зан үйлээс улбаалан уул овоогоо тахиж, үр тариагаа ургуулах, өсгөж өгөхийг гуйн өргөл мөргөл үйлдэж, эзэншүүлэх сэтгэлгээнээс тариалангийн зан үйл бий болсон. Үүнтэй зэрэгцэн аялгуут ба аялгуут бус аман яруу найргийн холбогдох төрлүүд ч мөн адил хөгжиж ирсэн байдаг.

Таван зүйлийн тариатай холбоотой зан үйл, бэлгэдэл нь хүмүүний зайлшгүй хэрэглээнээс үүдэн бий болсон идээ ундааны соёлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд монголчуудын нэгэн үнэт зүйл мөн болно.

Энэхүү таван зүйлийн тариатай холбоотой аман соёл, сэтгэлгээ нэн эртнээс үүсэн бий болсон ба үүнийг бид үнэт зүйлд холбогдуулан судлахаар зорьсон.

Таван зүйлийн тарианы зан үйл, бэлгэдлийг монголчуудын эрхэмлэн дээдлэх “Өв соёл” үнэт зүйлд хамааруулан үзэхдээ, түүхэн зүй, бэлгэдэл зүй, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, зэрэгцүүлэх, тайлан тайлбарлах зэрэг аргуудыг ашиглан судаллаа.

**Түлхүүр үгс:** *түүх, бэлгэдэл, хүмүүн, эд өлөг, сэтгэлгээ*

## The Culture to five species of grains is one of the Mongolian values

**Khorolsuren Battumur** 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia  
✉ horloo.0216@gmail.com

**Summary:** Since the beginning of human existence in Mongolia, food and beverage culture has been formed through the direct consumption of natural products such as natural fruits, wild grains, onions, mushrooms, and medicinal plants, and at a certain stage of development, the food culture was transformed into the cooking process by boiling, flavoring, refining, mixing.

When Mongolians are overwhelmed by the forces of nature, they pray to the gods, have faith in the hidden powers of heaven, and worship them for saving. Based on this faith, agricultural rituals emerged from the mindset of praying to the heavens and the earth, worshipping the mountains and hills, and making offerings to ensure growth and development. At the same time, genres of melodic and non-melodic oral poetry, related to farming rituals have been developed. We will study the oral culture and mentality associated with the five species of crops, which have existed since ancient times, concerning the most valuable priorities of Mongols.

As a result of the study of the most valuable priorities of Mongols, implemented by the Mongolian National University of Arts and Culture, within the framework of the project “Treasure of Mongols”, the President of Mongolia issued a decree on December 22, 2020, to honor the “Treasury Sutra” which was an important event in creating the unity, common interests, national consciousness, and unified spirit of Mongolians. The “Treasury Sutra” declares the Mongolian people, family, statehood, homeland, Mongolian language, Heritage, Nomadic wisdom, Education, and Morality as the most valuable priorities of Mongols.

This study aims to examine the rituals and symbols of the five species of grains concerning the theme “Heritage Culture - The Treasure” using historical, symbolic, analytical, summarizing, comparative, juxtaposition, and cultural narrative methods.

**Keywords:** *history, symbols, human, rituals, mentality*

### Оршил

Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс”-ийг улс орны түүхэн цаг үеийн онцлог үйл явдалтай уялдуулан, төрөл зүйлээр нь бүртгэн товчоолох, тодорхойлох ажлыг их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдад хариуцуулах гэсэн заалт бий. Мөн сурталчлан таниулах, хүртээн дэлгэрүүлэх, хүн бүрийн үндэсний ухамсарт суулгаж, сэтгэлийн чанадад хүргэн дархлаажуулахад бодитой хувь нэмэр оруулах хэмээн заасныг үндэслэн, соёлын өвийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хэрэглээнд гарч буй өөрчлөлт, таван зүйлийн тариатай холбоотой зан үйлийг таниулах, түгээн дэлгэрүүлэхэд энэхүү судалгааны ач холбогдол оршино.

Монголын газар нутгаас таван зүйлийн тарианд холбогдох эд өлгийн зүйлс, археологийн олдвор, хадны зураг, эдлэл хэрэглэл элбэг олдож буй нь тариалан эрхлэгчид амин зуулгаа залгуулах, амьдрал ахуйгаа авч явах зайлшгүй шаардлагаар тариа тарьж ургуулан хүнсэндээ хэрэглэж ирсний илрэл юм. Тухайлбал, "Үр үндэс нунтаглаж боловсруулах зууван дөрвөлжин хэлбэрийн самбар чулуу, бөөрөнхий урт гулууз маягийн нухуур, том бөөрөнхий толгойтой, бариулыг нарийсган зассан нухуур чулуу неолитын үеийн сууринаас олонтоо олддог нь мөнхүү үр үндэс түүх аж ахуй болон эгэл зээтүүт тариалан эрхэлж байсныг гэрчлэх хэрэглэгдэхүүн юм. Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгаас олдсон загасны хэлбэртэй (ам, заламгай, сүүлийг дүрсэлсэн) том хэмжээний үр үндэс, тариа цайруулах хавтгай самбар (ин) чулуу олдсон нь газар тариалан, загас агнуурын хоёр суурьшмал аж ахуйн холбоог илэрхийлсэн маш ховор, сонин дурсгал байдаг. Монгол орны чулуун зэвсгийн үеийн оршин суугчид ан агнуур, хожим мал аж ахуйн зэрэгцээ загас агнуур, үр үндэс түүх аж ахуйг байнга эрхэлж байсан ба неолитын үед анхны зээтүүт газар тариалангийн эх үүсвэр тавигдсан юм" (Шинжлэх ухааны академи 2003, 109) гэжээ. Газар тариалан эрхлэгчдэд байгаль дэлхийг хүншүүлэн ойлгох, уул ус, газар шороог далдын эзэнтэй хэмээн шүтэх нэн эртний ойлголт уламжлагдан ирснийг дээр дурдсан. Энэ нь тариалангийн зан үйл, бэлгэдэл үүсэх гол нөхцөл болсон бөгөөд мал аж ахуйтай эн зэрэгцүү цаг хугацаанд бүрэлдэн бий болж уламжлан хөгжиж ирсэн нь ойлгомжтой.

Монгол оронд будаа, буудайны судалгаа 1922 оноос эхэлсэн бөгөөд ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгаанаас үзэхэд, ... Манай оронд үр цуглуулсан анхны хайгуулаас хойш 40 гаруй жилийн дараах буюу Н.Г.Хорошайлов, А.Хүчит (1958), Х.Зундуйжанцан (1959), А.И.Иванов, Н.Нямжав (1966), С.Сүрэнгочоо (1968), Б.Бааст, Ж.Сэржээ (1972) нарын хийсэн хайгуул шинжилгээний ажлын үр дүнд нутгийн арвайн 355 дээж холимгуудыг цуглуулан бүртгэж, судлах болсноор ховор нандин үрийн сантай болж, түүнийг судлах сорилтын сантай болсон ажээ. Тэдгээр судлаачид судалгааны үр дүнгээ тодорхойлохдоо, Говь-Алтай аймгийн 10 сумын нутагт хамгийн олон буюу хоёроос найм, Ховд аймгийн есөн сумын нэгээс тав, Увс аймгийн таван сумын нутагт нэгээс дөрвөн янз зүйлийн арвай тус тус их тархсан байна. Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн цуглуулгад байгаа монгол арвайн олон тооны дээж нь орон нутгийн баялгийн чухал хэсэг болно (Сэржээ 1990, 15-16) гэж нутгийн сортуудын судалгааг хийж нэр төрлийн тооллого явуулж, арвайн төрөл зүйл, тархцыг тогтоон, буудайг баялаг хэмээн дүгнэсэн нь бидний энэ удаагийн судалгааны суурь, үндэслэл болж буйгаараа чухал ач холбогдолтой юм.

### **Судалгааны арга зүй**

Таван зүйлийн тарианы зан үйл, бэлгэдлийг монголчуудын эрхэмлэн дээдлэх "Өв соёл" үнэт зүйл мөн хэмээн авч үзэхдээ, түүхэн зүй, бэлгэдэл зүй, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, зэрэгцүүлэх, тайлан тайлбарлах зэрэг аргуудыг ашиглан судаллаа.

### Судалгааны үр дүн

Түүхч Б.Буянчуулган (1885-1937) “Монголын тариалангийн түүх” номдоо “Жи жы гэнь тун цзянь ган мү жян бэнь” бичгийн тэргүүн дэвтрийн дөрөвдүгээр хуудасны ард байсан таван зүйлийн тариаг тарьсан, тайлбарлан тэмдэглэсэн нь, “Вэй жи” бичигт өгүүлсэн нь, эртний иргэд өвс, модны цөмийг залгиж идэх, гөрөөс шувууны махыг идэж, тариалан үйлдэхийг мэдэхгүй бөлгөө. Янь ди (Шэнь ган ши-Б.Б) тэнгэрийн цагийг дагаж, газрын зүйг хянаж, модыг цавчиж анжис хийж үүсгэн, иргэнд таван зүйлийн тариа тарихыг сургах тулд тариалангийн хэргийг хөгжүүлэв” (Буянчуулган 2018, 20) хэмээжээ. Магадгүй түүврийн аж ахуй эрхэлж байсан тэр үед байгалийн зэрлэг амуу будааг хэрэглэж байгаад өрх гэрийн үйлдвэрлэх хүчин нэмэгдэхэд, гар аргаар будаа тариа тарьж, улмаар малыг гаршуулан тэжээж, хүнд хүчир тариалангийн ажил, уналга эдэлгээнд сургаж, ашиглаж эхэлсэн байж болох юм. Үүнийг тэдний үлдээсэн гайхамшигт өв хадны зураг, археологийн эд өлгийн зүйл, эртний хүмүүсийн амьдарч байсан бууц сууринаас харж болно.

Тухайлбал, Бичигт хадны зураг, Чандмань уулын булшнаас олдсон амуу тарианы үр зэргээс харж болохоос гадна Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг



*Зураг 1. Н.Сэр-Оджав,  
"Монголын эртний түүх" номоос*

Тэсийн гол, Булган аймгийн Орхон сумын Баруун могой, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгиогийн Алаг Чулуу зэрэг газрын хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед холбогдох хадны зурагт тусгай багажаар газар хагалж буй хүн, ганц буюу хоёр үхэр хөллөсөн анжсаар газар хагалж буй үйл явдлыг дүрсэлсэн байдаг. Төмөр зэвсгийн түрүү үед газар тариалан нэлээд ахицтай хөгжлийг олжээ. Тэр үеийн хүмүүс газар тариаланд зөвхөн зээтүү, царил зэрэг энгийн хөдөлмөрийн багаж

зэвсэг төдийгүй анжис хэрэглэн малын зүтгэх хүчийг ашиглаж байжээ” (Шинжлэх ухааны академи 2003, 171) хэмээн өгүүлсэн нь Монгол оронд тариалан эрхэлж байсныг нотлон харуулах бидний энэхүү судалгааны ажлын түүхийн гэрч болох нэгэн чухал зүйл юм. “Өмнөговь аймгийн Баянзагт оршин суугчид ...тариалан эрхэлж байсны баримт болох үр тариа цайруулах хавтгай самбар чулуу, нухуур, нүдүүр элбэг олдож буй нь неолитын сүүл үед тэнд оршин суугчдын аж ахуйд чанарын том өөрчлөлт гарсны гэрч юм” (Сумьяа 1999, 88) гэснээс үзэхэд, мезолит (НТӨ 12000-8000, сүүлчийн мөстлөгийн үеэс хойших жилийн тэртээх далайн төвшин нэмэгдэж, байгаль орчин өөрчлөгдөн хүн төрөлхтөн хоол хүнсний шинэ эх сурвалжийг хайж эхэлсэн үеэс эхэлдэг), неолит (НТӨ 7000-4000, хүмүүс газар тариалан эрхэлж хоол хүнсээ залгуулахаас гадна шавар вааран эдлэлийн урлал хөгжиж, боловсронгуй чулууг гөлгөр болгон зүлгэдэг болсон өнгөлгөөт чулууны үе)-ын үеэс Монгол орны үржил шимт газруудад оршин суугчид тариалан эрхэлж, будаа болон бусад ургамал тариалан хэрэглэсээр иржээ. “... Мезолитын үед хүний

эд, оюуны соёл, аж ахуйд өмнөх үеэс чанарын шинэ өөрчлөлт гарч энэ үеийн хүн байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг эзэмшихээс гадна газар тариалан, мал аж ахуй буюу үйлдвэрлэх аж ахуйд дэвшин орох эх суурийг тавьсан байна” (Шинжлэх ухааны академи 2003, 81) гэснийг үндэслэн мезолитын үеэс монгол нутагт анжист тариалан эрхэлж, таван зүйлийн тарианы соёлын үүсэл бүрэлдэн тогтсон гэж үзэж болох юм.

Мөн “Хятад сурвалж бичигт монгол Шивэй аймаг шар будаа, буудай тариалж байсан гэх агаад баяд аймаг Баргужин төхмийн орчимд тариа тарьж байжээ” (Гонгоржав 2008, 352). Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” бүтээлдээ “Ши Ци” зэрэг хятад сурвалж бичгийн мэдээнээс

... МЭӨ 119 онд Тяньянь уулын дэргэдэх Чжао синь сууринд хятадын цэргүүд хүннүгийн нөөц будаагаар хооллоод үлдсэнийг нь шатаасан байна Тяньянь уул хятадын эрдэмтдийн үзэж байгаагаар Хангайн нурууны урд шувтарга орчим байжээ. “Цзи су” гэдгийн “су” нь хар будааны нэг зүйл “хоног будаа”-г хэлнэ. Хүннү нар НТӨ 100-аад онд хятадын элч Су У-г будааны нүхэн зооринд хорьж байв. НТӨ 80 хэдэн онд хүннүгийн тариа боловсорсонгүй гэж “Цянь хань шу”-д дурджээ. Тан улсын тайлбарлагч Янь Ши-гу (581-645 он) тэд хар будаа тарьдаг гэжээ. Хүннү нар мөн НТӨ 66 онд баруун зүүн их жанжныг тус бүр 10 000 гаруй морьт цэрэгтэй Баруун хязгаар (Сиюй) руу илгээн нутгийнхаа өрнө хэсэгт цэргийн тариалан тариулж байжээ. Тэдний тариалангийн тухай хятад сурвалжийн эдгээр мэдээ хүннүгийн тухайд археологийн олдвороор нотлогдож байна. Ноён уул зэрэг газрын хүннүгийн булшнаас хар будаа (*Panicum miliaceum*) үр олдсон. Хүннүд холбогдох Иволгын балгаснаас арвай (*Hordeum vulgare* L), хар будаа, улаан буудайн үр олдсоноос гадна Ноён уулын булш Баруун дөрөөгийн хэрэм, Иволгын балгас зэргээс тариа хадгалдаг метр гаруй шавар ваар олдсон. Иволгын балгаснаас төмөр анжисны хошуу, хүрзний доод хэсэг, зээтүү, хадуур зэрэг тариалангийн багаж олджээ (Сүхбаатар 2023, 41) гэх мэт баримтууд нь монгол нутагт таван зүйлийн тарианы уламжлалт соёлын цаг хугацааг тодруулах эш баримт болж байна.

Азид цагаан будаа, шар будаа зэргийг хэдий үеэс тархсан талаар эрдэмтэд өөр өөрийн байр сууриа илэрхийлсэн бүтээлүүд хэвлүүлсээр байна. Цагаан будааны тариаланг өмнөд энэтхэг, хятадын өмнөд мужаас үүсээд, улмаар хятадын зүүн өмнөд нутгуудаар тархсан гэжээ.

... Плейстоцений (мөстлөгийн үе) дараах зэрлэг будаа мөстлөгийн үеийн халуун орны өмнөд нутгаас хойд зүгт зүүн Хятад болон Янцзын (Хөх мөрөн) сав газар хүртэл тархсан гээд одооны газрын зураг өөр, төөрөгдөлд хүргэж, магадгүй сүүлийн хэдэн мянган жилийн хугацаанд хүний үйл ажиллагаа, ялангуяа намгархаг газрыг хөдөө аж ахуйн зориулалтаар нөхөн сэргээх замаар зэрлэг будааны амьдрах орчныг устгасан явдал юм. Үүний үр дүнд олон тооны зэрлэг будааны популяци устсан байх магадлалтай. Үүнийг нотлох баримт нь Сүн гүрний үеийн хятад бичвэрүүдээс 1000 гаруй жилийн өмнө (үндсэндээ цаг уурын нөхцөлд) байдаг бөгөөд энэ нь хятадын цутгалан Доод Янцзы, хойд зүгт Шандун хүртэл зэрлэг будааны популяци байсныг илтгэдэг” гээд “Шар будааны тариалан хожим Зүүн Сибирь (Приморье) болон Солонгост дэлгэрч



байснаас үзэхэд эртний шар будааны соёлууд “Микро-Алтай”-тай холбогдон (Тунгасик, Солонгос, Бленч) тархсан байх магадлалтай (Dorian Q. Fuller 2011, 79, 84) гэжээ.

Энэхүү Микро-Алтайд Монгол Алтайн нурууны салбар уулс, түүний орчин тойрны тариалангийн газрууд багтана.

Б.Буянчуулган “Ган мү” 25.52 өвөрт, Вэй улсын Тай Пин Жэ Жюнь-ий тавдугаар (444) онд Вэй улсын Тайжи Тоба Хуан зуун түшмэдийг ерөнхийлөв. Тоба Хуан иргэний тариалан тарихыг хөхиүлж, үхэргүй ардыг хүний үхрийг хэрэгсэж, оронд нь эрчиж хариулмай. Бүгд хорин хоёр үр<sup>1</sup> тариалан хагалбарлан тарьсанд долоон үр тариалан эрчимүй. Их төлөв үүнийг хэмжээ болгожээ. Иргэнийг өөр өөрийн тариалангийн захад нэр овгийг модонд бичүүлж, түүний хичээлтэй залхууг ялгах, архи уух, зоос наадахыг цаазлах тул түүнээс хагалбарын тариалан их л нэмэгдүүлэв” (Буянчуулган 2018, 21) хэмээн Тоба Вэй улсын үед тариалан эрхэлж байсан баримтыг хятад сурвалжаас эш татжээ. Үүнээс үзэхэд, эртний монгол аймгуудын нэг Тоба Вэй улсын жанжин хүн ардынхаа бардам, залхуу занг дарахын тулд тариа тариулж, будааны тариалалтаа нэмэгдүүлж байсан нь харагдаж байна.

“Сэлэнгэ орчмоор нутаглаж байсан Мэргидүүд тариалан эрхэлж байсан бөгөөд Монголын эзэнт улс байгуулагдсаны дараа Аргун Агад албан тариа тарих үүрэг өгч, Чинхай хотыг байгуулан дарангуй цэрэг сахиулжээ. Тэр үеийн тариалангийн газрыг урьдчилан боловсруулдаггүй, модон анжсаар газраа хагалан, малын хэвтэш бууцаар бордож, үрийг гараар цацна, тариа ургамагц, гараар хадан, малаар гишгүүлж хальслаад, салхиар цайруулан, арьсан шигшүүрээр шигшиж, уурт нүдэж гурил болгоно. Түмэдийн Алтан хан Хөх хотын орчим их хэмжээний тариаланг үүсгэсэн” (Баярсайхан 2017, 139) гэх мэдээ бий.

Монгол нутагт усалгааны системтэй тариалангийн талбай уламжлагдан ирсэн бөгөөд байгальд ээлтэй өвөг монгол тарианы үрээр экологийн тэнцвэрт байдлыг ханган тарьж ургуулах соёл өвлөгдөн иржээ.

Юань улсын судрын Хөгжмийн бүлэгт “Шороо тариалангийн хөгжмийн бүлэг” хөгжмөөр тариалангийн бүхий л үйлийг илэрхийлсэн бөгөөд архи дарс тэргүүтнийг хийж өргөл өргөх хүртэлх үеийг оруулжээ. Үүнд,

... Сахиулсанд буухад оршилтой эсний аялгууг үүсгэнэ. Цогцолсон хөгийн орд хоёр төгссөн. Шороо болой газар болой, улсад сайн хууль буй амуу. Их болой агуу эрдмээр, туйлын төр хол үргэлж. Тариалангийн гавьяа түмэн үе тул, үүгээр үндэст хариулна. Илэрхий тусалж дотуураар ивээн, бууж мандал тавцанг толилно.

Их чуулалт хэдаагуун хоёр төгссөн

Иргэнд газрын ашгийг хүртээсэн, тэрхүү гавьяа нь их л нийгэм. Үеийн хууль ёслолыг тодорхойлон, ариун дуу нь арга эгшиг билиг эгшиг. Сайн өдөр илэрхий тул, мөлийн мөлийн бууж ирнэ. Энд туслахад жил бүхий тул, уг үндэс улмаар бэх.

Ариун угаал жидаагун хоёр төгссөн

Тэрхүү шороо усыг төвшитгөөд, элбэг тариа тийнхүү боловсорно. Хэзээд гэгээн

<sup>1</sup> Үр-талбайн хэмжүүр, 0.09216 га газартай тэнцэнэ. Энэ нь 360 дөрвөлжин алд газар ажээ.

улирлыг төгссөн тул, эрдмийн үнэрийг амсах нь зохистой. Таван тахилгад их болгоод, мянга үед цөм явжээ. Тахил тавил хөдөлгөж нэвтрээд, дэвшиж дуулах нь оршилтой эсэн.

Төгсгөлийн билиг эгшиг юудаагун хоёр төгссөн

Хэвийг тэгш үнэнхүүгээр засаж, агуулсан амс амуу бүрдээд. Сан хашлага нийслэлд хүрчээ, хамгаалан ивээсний хишигт. ...Анхан өргөх ба угаах зайлахад хэмэнт эсний аялгууг үүсгэнэ... (Юань улсын судар 2021, 410, 411) хэмээн хөгжмөөр тариа будааг тариалахаас хураах хүртэлх үеийг илэрхийлсэн байна. Үүнийг тусгайлан судлах шаардлагатай.

### **Таван зүйлийн тариатай холбоотой аман соёл**

Монголчууд таван зүйлийн тариатай холбоотой аман яруу найргийн арвин баялаг сантай. Үүнээс цухас дурдвал, Өвөр монголын монгол тулгар бичгийн цуврал (Цэвшиг, Сарангэрэл 1982)-ын “Дээд монголын үлгэр домог” бүлэгт таван зүйлийн тарианы үүслийн тухай домгийг судлаач Цэвшиг, Сарангэрэл нар сурвалжлан олж тэмдэглэн оруулжээ. Үүнийг бүрэн эхээр сийрүүлбэл,

**Таван тариа.** Эрт урьдын цагт хоёр айл хот хошоо болон амьдарч байж гэнэ. Нэг нь яах аргагүй нэртэй баян айл, нөгөөх нь идэж өмсөхдөө зөвгүй ядуу айл байж гэнэ. Энэ хоёр айл нэг нэг нохойтой юм байжээ. Баян айлын эзэн нь нохойдоо хоол өгдөггүй, хоосон сойж өдөр шөнөгүй уядаг байж гэнэ. Ядуу айлын эзэн нь өөртөө ч идэх хоол элбэг биш боловч олж ирсэн жаахан хоол будаагаа нохойтойгоо хувааж иддэг байж гэнэ. Тэгж байтал баян айлын нохой бүр эцэж тураад хатаасан хар борц шиг болжээ. Ядуу айлынх нь нохой харин тарган цатгалан, үс ноос нь гялгар хар бараан байдаг юм гэнэ. Нэг удаа өдөр шөнөжин бороо оржээ. Үзэх үгүй их үер буугаад энэ хоёр айлыг тууж, гэр мал юу ч үгүй болгожээ. Айлын эзэд нь арай гэж хар биеэ л авч гарсан гэнэ. Хэдэн хоногийн дараа ядуу айлынхан бууриа эргэхээр ирэхэд, өвс модыг хүртэл онги түнгээр (уг үндэс) нь урвуулаад туучихсан тул үлдсэн суусан юм гэж үгүй. Ганц баян айлын буурь дээр баяны нохой нь л уяатай ёсоороо улиад зогсож байсан гэнэ. Ядуу айлын эзэн санаа зовж, тэр нохойг уяанаас нь тайлж аваад хөдлөхөд явж өгдөггүй гэнэ. Тэгэхэд ондоо айлын эзэн гэж танихгүй бололтой гэж бодоод орхиж явжээ. Маргааш нь ядуу айлын эзэн бага сага хүнс олоод харих замдаа “өнөө нохой явсан үгүйг үзье” гээд баян айлын буурь дээр хүрэхэд тэр нохой бас л уяан дээрээ зогсож байв гэнэ. “Энэ нохой өлсөж харангадаад хөдөлж чадахгүй болсон байлтай” гээд олсон жаахан хүнснээсээ усанд зуурч идүүлээд хөдлөхөд баруун өмнөд хөлөөн газраас огт салгадаггүй гэнэ. Үерт урсаж ирсэн таван тарианы тавхан үрийг энэхүү хөөрхий амьтан тавгаараа дарж авсан юм байжээ. Түүнийг нь түүж аваад явахад тэр нохой сая нэг санаа нь амарсан юм шиг ядуу айлын эзний энд тэнд нь гаран үсэрхийлэн дэлдэж өөрөө дагаад явж гэнэ. Тэгээд энэ ядуу айл, тэр нохойн үерээс авч суусан таван тарианы үрийг тарьж, тариа төмстэй баян чинээлэг амьдрах болсон гэнэ. Монгол хүн анх ингэж тариа тарих болсон гэдэг. Нохой тэжээвэл цадтал нь идүүлдэг нь ийм учиртай ажгуу. Хөдөөгийн малчид ч нохойг их хоолны буянтай амьтан гэж их хоол өгдөг байна. Ингэвэл идэш ууш элбэгжиж, аж амьдрал сайжирдаг гэж настайчууд хэлдэг юм. Давсанговийн настай малчин Даваа

хэлж, Цэвшиг, Сарангэрэл нар эмхэлбэ (1982 оны 8 сар)” (Сёбсиг 1986, 128-129) гэсэн домог бидний үед уламжлагдан ирсэн нь таван зүйлийн тарианы үүсэл гарлын домог юм. Домгийн агуулга нь монголчуудын тариа будаа, хүнс хоолыг хэцүү бэрхийг даван байж нохой олж өгсөн хэмээсэн утгатай байна. Бидний хээрийн шинжилгээний явцад тариатай холбоотой домог, зүйр цэцэн үг, оньсого таавар, ерөөл магтаал, бэлгэ дэмбэрлийн болон хэлц үг, сацал мялаалгын үг зэрэг аялгуут ба аялгуут бус аман яруу найраг, дуу, бүжиг, хөгжим зэрэг урлагийн төрлүүд тэмдэглэгдсэн нь таван зүйлийн тариатай холбоотой соёлын ай сав хөгжсөнийг илтгэнэ.

Таван зүйлийн тариа бол монголчуудын уугуул хоолны эх бөгөөд олон хоногоор гэр орноосоо хол явах, дайн тулалдаанд орох зэрэгт арвайн гурилыг ямааны арьсан туламд гурван жилийн хүнс болгон хийж авч явдаг байжээ. Ялангуяа арвай өдөр тутмын хүнсний хэрэглээнд (хүнсний болон эрүүл ахуй, янз бүрийн зан үйлд) чухал үүрэгтэй байсан тул түүнийг дээдлэх, зан үйлдээ хэрэглэх, ард түмний сэтгэлгээний өвөрмөц тусгал болгож иржээ. Тариалан эрхэлж байсан ардууд таван зүйлийн тариаг эмчилгээний гарын доорх материал болгон ашиглаж ирсэн нь өнөөг хүртэл өвлөгдсөөр байна. Тухайлбал, хамрын ханиад хүрэхэд арвайн гурилаар утаад эдгээнэ. Гэдэс гүйлгэхэд хөөрүүлсэн сүүнд арвайн гурил зуураад өгнө. Өтгөн хатахад түүхий сүүнд салтал нь зуураад өгнө гэх мэтийн олон өвчинд хэрэглэдэг байна.

*Арвайгаар өвчин засах:* Арвай бол тамирыг төлжүүлж, бадган шарыг арилган, шингээлтийг сайжруулах чадалтай. Арвайг хонины махны шөлөнд чанаж, өчүүхэн төдий сонгино нэмэрлээд хоол хийж идвэл галын илчийг сэлбэж, ходоод дэлүүг сайжруулан, хийг доош явуулах ба хэвлий хөөхийг засдаг.

*Хөх арвайгаар өвчин засах:* Хөх арвай хүүхдийн ханиад ба халуун бүрхсэн, гэдэсний хагталгыг арилгадаг.

*Хар арвайгаар өвчин засах:* Хар арвай яр нөсөөг арилгадаг. Шатаасан хөх арвай уушгины халууныг дардаг гэх мэт монгол амуугаар өвчин засах, Тутарга, Нарим будаагаар өвчин засах, сагагаар өвчин засах зэрэг анагаах сувилахуйд ашигладаг байна (Чулуунбаатар 2020, 694-695).

Мөн хүйтэн цайнд цацахад халуун сэтгэгдэл төрүүлнэ. Халуун цайнд цацахад л цайг хөрсөн мэт сэтгэгдэл төрүүлэх идтэй шидтэй гэж нутгийн ардууд байнга хэрэглэнэ. Мөн шашны болон өдөр тутмын зан үйлд хэрэглэдэг. Тариачид эрхлэгчид таван зүйлийн тариа тарьж илүүдэл тариагаа зарж, эдийн засгийн эргэлтэд оруулдаг байсан нь тариагаа хальснаас нь салгаж салхинд хийсгэхдээ ангилдаг технологиос мэдэгдэж байна. Хүрэээр салхины эсрэг тариагаа шидэхэд хөлд хамгийн ойр унаж буйг хүнд жинтэй хөрөнгө тариа хэмээн дараа жилийн үрэнд хэрэглэхээр нөөцөлнө. Харин түүний цаана унасан тариаг сайн тариа хэмээн өөрсдөө идэхээр, түүний цаана унасныг зарах тариа гэх зэргээр ялган хэрэглэдэг байжээ. Тариачид “үрээ идэхээр үхрээ ид” гэдэг үгийг мөрдлөг болгоно. Энэ нь ирэх жилийн тарих үр хэчнээн үнэ цэнтэй дараа жилийн хүнс байснаас үүдэлтэй.

1212 онд Чингис хааны зарлигаар байгуулагдсан Чингай балгас. 2004 онд Монгол Японы хамтарсан “Бичээс” төслийн баг Говь-Алтай аймгийн Шарга сумын Халзан ширэг хэмээх газар малтлага хийж өгүүлэл бичжээ. “...Сурвалж



бичигт тэмдэглэснээр, XIII-XIV зууны зааг үед Чингай хот, түүний орчин тойронд тариа, ногоо тарьдаг хятад, зүрчид, солонгос 2000 гаруй орчим хүн (цэрэг) суудаг байсан бөгөөд тэд 3-5 жил болоод солигддог байж. Бас Дундад азиас ирсэн хүмүүс жимс ногоо тариалан сууж агсныг Чан Чунь бумба үзжээ. Чингай нь тухайн үедээ зөвхөн будаа, тариа, бусад хүнс бэлтгэдэг төдийгүй цэрэг бэлтгэдэг боомт хотын үүрэг гүйцэтгэдэг байв” (Очир ба бус. 2015, 168-181) гэснээс үзэхэд Чингай балгас цэрэг дайны зориулалтаар баригдаж, цэргийн дамжин өнгөрөөх үүрэг гүйцэтгэж, тэднийг хоол хүнс, тариа ногоогоор хангах түшиц хот байжээ. Чингай балгасын газар зүйн байршлыг тогтоохоор гадна дотнын түүхчид өөр өөрсдийн таамгийг дэвшүүлсээр байна.

### **Таван зүйлийн тариатай холбогдох зан үйл, бэлгэдэл хэрэглээний соёл**

Зан үйлийг эрдэмтэд “... ямар нэгэн үйл, үйлдэл, бодол сэтгэл, сэтгэгдлийг бэлгэ тэмдгийн утгаар илэрхийлэх юм уу хийсвэр санааны нөлөөллийн бодитой юм үзэгдэлд ургуулан тусгах учир зорилготой зан аалийн зүйл ялгалыг зан үйл гэнэ” хэмээн тодорхойлжээ. Зан үйл угсаатны дотоод хэлхээ холбоог уламжлуулах, соёлын туршлагыг хуримтлуулан дамжуулах, угсаатны өвөрмөц байдлыг хадгалах, хүмүүсийн аж амьдралын хэв ёсыг сахиулах мэргэн зохицуулагч, эд өлгийн болон оюуны соёлын тулгуур шинж юм. “...зан үйл гэдэг бол бэлгэдлийн цогцолбор чуулбар шинжтэй байдаг бол зан аалийн бэлгэдэлт шинж нь хараахан цогцолбор бус шинжтэй юм” (Дулам, Нандинбилиг 2007, 61) гэснээс үзвэл, таван зүйлийн тариатай холбоотой зан үйл нь тариалан эрхлэгчдийн тухайн үйлийг бүтээх зан заншлаас урган гарсан бэлгэдэл юм. “Бэлгэдлийг судлахад зайлшгүй хөндөгддөг нэгэн өргөн агуулгатай сэдэв бол зан үйл (ritual) юм. Тийм ч учраас Ш.Ортнер бэлгэдлийн тогтолцоог тайлбарлахдаа бэлгэдэл гол төлөв өрнөх талбар, нийгмийн орчин болох зан үйлийг авч үзсэн байдаг. Тэрээр зан үйлийн талаарх шаталсан гурван зүйлийн тайлбарыг боловсруулсан байна” (Moog 2004, 311) байна. Нэгд, зан үйл гэдэг бол юу юунаас илүү утга учрын тогтолцоо бөгөөд үүнд ертөнцийн бүтэц бүрдэл, ирээдүйн тухай үзэл санаа, үнэт зүйлс, зорилго чиглэл, асуудлууд багтаж байдаг. Хоёрт, зан үйл гэдэг бол үйлдэгч ухамсар болон үйлдэгчийн оршин буй соёлын мөн чанар хоёрын нэгдэл бөгөөд үйлдэгч соёлын мөн чанарынхаа хүрээнд өөрийн ухамсраа хэлбэржүүлэх замаар үйлдлийг гүйцэтгэдэг байна. Өөрөөр хэлбэл, хувь хүний ухамсар оролцож байх боловч тэр нь өөрийн соёлын хүрээ хэмжээн дотроо ажиллаж байдаг гэсэн үг. “Ингээд соёл гэдэг бол утга учир бүхий бэлгэдлийн тогтолцоо бөгөөд энэ тогтолцоо нийгмийн амьдралд тулгардаг зөрчилтэй зүйлийг даван туулах үйл хэргийн заавар, төлөвлөгөө болдог” (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018, 175) гэсэн нь таван зүйлийн тариатай холбоотой соёлыг бий болгогч хүний оюун санаанаас нийгмийн хүрээнд оруулсан хувь нэмэр бөгөөд соёлын бүтээл, үүнийг бүрдүүлэгч зан үйл нь үр суулгахаас хурааж авах хүртэлх өдөр тутмын хөдөлмөрийн үр шимд буй болон, байгалийг шүтэн аргадсан, аялдан дагалдсан, гуйсан хүссэн, ирээдүйн сайн сайхныг зөгнөсөн, хүний аж амьдралыг сэтгэл хангалуун байлгах гэсэн өвөрмөц зорилго бүхий соёлын орон зай юм.

Таван зүйлийн тариан дотроос арвайг монголчууд эрт үеэс өсөн үржихүйн бэлгэдэл гэж үздэг төдийгүй өрх гэр тусгаарлахад хадагт боож, тоононоос уях, байр, байшингийн сууринд өргөх, нас барагсдын оршуулгад өргөл болгон хийх

зэрэг олон зан үйлүүдэд хэрэглэдэг байжээ.

Арвайг өсөн үржихүйн бэлгэдэг болгодог учир нь арвайн нэг үрийг тарихад доод тал нь хориос зуугаад ширхэг сүрэл болно. Нэг сүрэлд 50 ширхэг үр ургана гэвэл 2000-5000-аад ширхэг тариа болон өсдөг байна. Арвайн үржих тоо нь түрүүний үрийн байрлалаас шалтгаалдаг бөгөөд хоёр үрт хоёр эгнээ, гурван үрт гурван эгнээ Монгол арвай зургаан талт гэх мэтийг илүү тариалдаг бөгөөд сайн ургац хураадаг байна. Мөн эрдэнэт хүмүүний биеийг олж төрөх нь дээш харуулан тавьсан зүүний үзүүрт асгасан арвайнаас тогтож үлдсэн ганц арвайтай зүйрлэн адилтгаж, энэ бол их хувь тавилан гэдгийг ойлгуулсан буддын ухааны зүйрлэл байдаг.

Таван зүйлийн тариаг монголчууд уул усаа тахих, гэр байшингийн суурь тавих, шинэ гэр бүл болох, нөхцөгсдийг оршуулах, хүүхэд төрөхөд эхэс оршоох, нүдэнд цагаа унах зэрэг олон зан үйлд домын шинжтэй хэрэглэж дээдэлсээр ирсэн байна.

Эдгээрийг археологийн малтлага судалгаанд суурилан тодруулбал, У.Эрдэнэбат, К.Франкен (ХБНГУ), Т.Батбаяр нарын “Хархорумын Цогт их сүмийн гэр буюу Юань улсыг мандуулах асар” өгүүлэлд: “Барилгын суурийг дэлдэх үед тэнд аравнайж тавьсан өөр дөрвөн шүншгийг 2014 онд явуулсан археологийн судалгаагаар илрүүлэн олсон нь онцгой ач холбогдолтой. Сүмийн шүншигт тариа будаа, төрөл бүрийн жимс, алтан утастай торгонд боодолтой “өсөн эрдэнэ” (үүнд: Монгол гүрний их хаадын алтан зоос 2 ш, мөнгөн зоос 3 ш, шүр, сувд, оюу) орсон бөгөөд тэдгээрийг том вааран саванд хийж амсрыг нь шавар тагаар таглаж тавьжээ. Өсөн төрлийн материалаас бүрдсэн эд юмс нь бүтээн цогцолсон суварга шүтээнийг амилуулан тэтгэх нарийн нандин бэлгэтэй ажээ” (Эрдэнэбат, Франкен, Батбаяр 2015, 182-188) гэсэн нь уг барилгын суурийг тавихдаа тариа будаа хийсэн байгаа нь будаа шиг арвин их ном хурж, олон хүнийг үеийн үед жаргааж, амар амгалан, үхэшгүй мөнх байлгаж арвай будаа шиг арван зүгтээ дэлгэрэг гэсэн бэлгэдэлтэй юм.

Монголчууд шинэ гэр бүрж, идээ ундаа элбэг дэлгэн, гэрийн тоононоос хадагт боосон арвай будааг зангидан уяж, үр хүүхдээр өнөр өтгөн, идээ ундаагаар бялхаж, элбэг дэлбэг амьдрахыг бэлгэддэг. Арвай бол өсөн үржихүйн бэлгэдэл юм. Үүнийг С.Дулам:

Эртний Аккад, Шумер, Вавилон, Ассирын улсууд ...НТӨ VII-VI мянган жилийн үед умард Месопотамид ...анхны хот суурин үүсгэжээ. Тэдний оршин суугчид үндсэндээ тариалан эрхэлж байв. Энэ үеийн Хассуны соёлыг бүтээгчид болох Хассун омгийнхон бүгд бод мал үржүүлдэг, улаан буудайн гурван зүйл, арвайн дөрвөн зүйл тариалдаг байв. Чингээд хоёр мөрний хөндийнхөн болох Ойрхи Дорнодын урлаг, соёлд арвай нь үржил шимийн болон үхлийн дараах амьдралын бэлгэдэл болдог байжээ. ...Нил мөрний үржил шимт хөндийд соёл иргэншлээ үүсгэн мандуулсан Мисир-Египетэд арвай нь үржил шимийн тэнгэр Осирисийн дахин амилахуйтай холбоотой ажээ. Мөн эртний Грекийн домог зүйд ч гэсэн арвай нь үржил шимийн тэнгэр Деметра болон түүний хулгайлагдсан охин Ферсефонатай холбогддог юм байна. Энэ бүхнийг дурдахын учир нь хүн төрөлхтний соёл иргэншлүүдийн бүтээл болсон арвайн соёл, утга бэлгэдэл нь манай монгол угсаатны тэр дундаа Богд Жэбзундамба хутагтуудын хуврагын аймгийн Гэгээн сангийн дөрвөн арвайн буюу “найши” тамганы бэлгэдэлтэй яв цав нийцэж, монгол иргэншил дэлхийн томоохон иргэншлүүдтэй амин судас холбоотой явж ирснийг илэрхийлж байгаад оршино (Дулам 2018, 481, 482)

гэж дүгнэж шинжилсэн нь монголчуудын арвайн соёл дэлхийн голомт бүхий соёлоос дутахааргүй өргөн ойлголттой, язгуурын шинжээ хадгалан баяжиж ирснийг нотолж байна.

Мөн эхсийг оршоох ёсд: “Хойдох нь цөглөж” эхэс унахад эх барьсан хүн эхэс оршоох ёсыг гүйцэтгэдэг. Эхэд нь хүүхэд төрөнгүүт “эхэс төддөггүй” гэж монгол үнээний түүхий, бүлээн сүү юм уу, хужиртай бүлээн ус балгуулдаг байжээ. “... Хүүхэд унасан газарт арц уугиулж, тэнд эхсийг оршоож байв. Эхсийг хур үнсэнд юм уу, эсвэл эхэс оршооно гэж гараад үнсэндээ булах, эхэс дээр тариа будаа “үрийн үйл” гэж цацаад жингэрт хаяж өгдөг заншил ч бий...” (Арьяасүрэн, Нямбуу 2023, 330) гэсэн нь нэн сонирхолтой дом байна. “...Захчинд бол долоон ширхэг арвай авч, нэг нэгээр нь бог унасан нүдэнд барьж шившээд, нүдний өмнүүр эргүүлж байгаад ус руу хаяна. Долоон орой ийн домновол усан дээгүүр нь үүл мэт юм хөвөөд сая эдгэрдэг гэдэг байна” (Дулам, Нандинбилиг 2007, 82).

Эртний монголчууд оршуулгын зан үйлд арвай, будааг их хэрэглэдэг. Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү нарын “Таван толгойн монгол язгууртны булшнууд”-д хийсэн малтлагаар илэрсэн эд өлгийн зүйлд тариа будаа байсан талаар “...Авсны дотор, толгой болон хөл талд их хэмжээний үр тариа хийж дэвссэн ба дугуй хээтэй улаан өнгөтэй торгоор битүү доторлон түүнийгээ дахин банзаар дарж хадан, гадуур нь гурван үе төмөр бүсээр бүслүүрдэн хийжээ...” (Төрбат, Батсүх, Баярхүү 2015, 192) Энэ булшинд дэвссэн их хэмжээний үр тариа нь нас барсан хатан хойд насандаа үр тариагаар хооллож, дахин төрж хүний орчлонд эргэн амьдрах, мөнх оршихын бэлгэдлийг илэрхийлсэн байна. Мөн таван өнгийн будааг шашны болон өдөр тутмын зан үйлд янз бүрийн бэлгэдлээр хэрэглэдэг.

Эрдэмтэн С.Дулам Гэгээн сангийн арвай тамганы бэлгэдэлд холбогдуулан ... Богд Жэбзундамба хутагтын найман дүрийн үед байсан хуврагийн аймгийн сан жасын мал сүрэг тэргүүтний тамгын зүйл, тэр дундаа “дөрвөн арвай” буюу “найши” тамганы тухайд сонирхон үзвээс монголчуудын ургамлын бэлгэдэлт тамганы тухайд болон ер нь энэ тамганы соёл нь бүр хүн төрөлхтний эртний соёл иргэншлүүдтэй ямархан сэжмээр учир холбогдолтой болох талаар сонин сэрвүүн бодол санаанд хүргэж байна. Эрдэнэ шанзодбын яаманд байдаг Богд гэгээний сүргийн тамгыг анх Өндөр гэгээн Занабазар (1636-1723) зохиосон гэдэг мэдээ баримт, түүний олон намтарт дурдагддаг. Мөхөс бичээчийн номын санд буй “Очирдара Богд гэгээнтний гурван дүрийн намтар энэ болой” хэмээх гар бичмэл сударт: ... “Бас Гэгээн танд сан сүргийн тамгыг ямар хэлбэртэй байваас болох буй хэмээн айлтгасанд “Найши гэж хийгүгэй” хэмээсэнд “Найши гэгчийг мэдэхгүй” учрыг айлтгасанд “Дөрвөн арвай буй” хэмээжүхүй. Дөрвөн арвайгаар яаж болох буй хэмээсэнд “Дугариг юманд дөрвөн арвай талбиваас таван нүдтэй болох буй. Арвай гэгч монгол үг буй. “Найши” гэгч төвд үгээр найши хэмээсэн нь янагш ирж үржихүйн бэлгэ. Таван нүд нь дөрвөн аймгийн дунд тахигдахын бэлгэ” хэмээн айлтгасан гэдэг” (Дулам 2018, 479-482) хэмээснээс үзэхүл, монголчуудын уламжлалт таван зүйлийн тариатай холбоотой бэлгэдэл маш өргөн хүрээтэй хэрэглэгддэг нь дээрх баримтуудаас тодорхой харагдаж байна. Мөн шашны зан үйлд үрийн таван зүйл хэмээн “арвай [тө: nas dang] найши (арвай будаа), [тө: sran ma] сранма (буурцаг), [тө: thil de lnga] хүнцэд дэл (хар будаа), [тө: dro] (буудай), [тө: ‘bra bo] тутарга,

(цагаан будаа)...” (Хао бүн шон, Доу цинчи 1987, 278) хэмээн нэрлээд таван зүйл тариа будааг зан үйлдээ хэрэглэж иржээ.

### Хэлэлцүүлэг

Монголчууд таван зүйлийн тарианы өргөн соёлтой ард түмэн байсныг гэрчлэх баримтууд бий. Тухайлбал, Ромын Пап лам IV Иннокентийн элч төлөөлөгчөөр монголын их хаанд бараалхсан Пано Карпини ламын тэмдэглэлд: “...Тэд өвлийн цагт цагаан будаа, шар будаа, арвай, зөгийн бал тэргүүтнээр дарс мэт сайхан амтат ундаа хийнэ, харин дарсыг алс холын орнуудаас авчирна...” (Пано Карпини 1988, 109) гэж арвай будаагаар архи нэрж, будаагаар хийцтэй цай, ундаа бэлтгэдэг байсныг харь хүний сониуч зангаар тодорхой бичсэн бөгөөд хөрш орнуудтай дарсны наймаа хийж, худалдаа хөгжсөнийг нотолдог.

Эдгээрийг нэгтгэж үзвэл, таван зүйлийн тарианы зан үйл бэлгэдэл нь язгуурын уламжлалт соёл бөгөөд монголчуудын өнө эртнээс уламжлан ирсэн тариа тарих арга туршлагатай холбогдон бий болсон нь батлагдаж байна.

### Дүгнэлт

Таван зүйлийн тариатай холбоотой соёлыг монголчуудын үнэт зүйлд хамаатуулан үзэж, зан заншил, хэрэглээ, утга бэлгэдлийнх нь талаас судлах зорилгын хүрээнд дараах хэдэн чиглэлээр шинжилж үзлээ.

Монгол нутагт тариалан эрхэлсэн үеийн түүхэн улбаа нь нэн эртнээс бөгөөд эрдэмтдийн бүтээл, археологийн малтлагаар илэрсэн эд өлгийн зүйл, хаднаах зурагт тулгуурлан хүрлийн үеэс ул мөр нь мэдэгдэж эхлээд төмрийн үед хөгжингүй тариалан бий болон хөгжжээ. Таван зүйлийн тариатай холбогдох хамгийн эртний баримт бол Чандманийн соёл бөгөөд энэ үед холбогдох оршуулгаас үр тариа гарсан нь бидэнд нотлох баримт болж байгаа юм. Ихэнх судлаачид хөгжингүй тариалан мезолитын үед эхэлсэн гэж үздэг хэдий ч түүнээс өмнө тариалан байсан учраас анжист тариалан бий болсон гэж үзэж болохоор байна. Мөн Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигт, Булган аймгийн Орхон сумын Баруун могойн хаднаах зураг зэргийг судалсан эрдэмтэд хүрэл буюу төмрийн түрүү үед хамааруулан үзсэн байдаг.

Монголчуудын тариа тарьж байсан тухай мэдээг үе үеийн түүхчид, судлаачид бүтээлдээ тэмдэглэн үлдээсэн нь өдгөө бидэнд эх сурвалж, хэрэглэгдэхүүн болох нөхцөлийг бүрдүүлсэн нь чухал ач холбогдолтой. Эдгээр баримтад тулгуурлан монгол нутагт ээлж дараалан оршин тогтнож байсан эртний улсууд, Монголын эзэнт гүрний үе, түүнээс хойших үеийн түүхэн сурвалжуудад таван зүйлийн тариалангийн соёл байсныг бататгах тул үүгээр дамжуулан таван зүйлийн тарианы соёл эртнээс улбаатай байжээ хэмээн үзэж байна.

Таван зүйлийн тариатай холбоотой аман яруу найраг нэлээд байна. Үүнээс бид “Таван зүйлийн тарианы үүсэл гарлын тухай” домгийг авч үзэж, тариаг үрлэхээс хураах хүртэлх үйл явцад бэлгэ дэмбэрлийн үг, ерөөл магтаал, дом шившлэг, үлгэр домог, оньсого таавар зэрэг аман яруу найраг, урлагийн төрлөөс дуу, бүжиг, хөгжим зэргийг бүтээж хэрэглэж ирсний илрэл “Юань улсын судар”-аар уламжилсан “Тариалангийн хөгжим” юм.

Мөн аман яруу найраг цаг хугацааны явцад үүрэг зориулалтаа даган өөрчлөгдөн шинэчлэгдэж байдгийг “Үтрэмийн ерөөл”, “Баян сахлын ерөөл” зэргээс харж болно.

Тариалантай холбоотой зан үйл, аман соёл тухайн газар нутгийн онцлог, цаг уурын төлөв байдал, хүмүүний аж амьдралын нөхцөл байдал зэрэгтэй уялдан бий болж, тариаланчдын арвин баялаг мэдлэг туршлага, эрдэм ухаанаар дамжин хойч үедээ өвлөгдөн ирсэн нь чухал үнэт зүйл юм. Хамгийн гол зүйл нь тарианы үрээ нандигнан эрхэмлэж, хатуу сэрүүн нөхцөлд дасан зохицсон өвөг сорттой болсон явдал юм. Энэ нь хэдэн зуун жилийн түүхийн туршид бий болжээ. Цаашилбал, илүүдэл тариагаа зарж борлуулах, хөдөлмөрийн шинэчилсэн хуваарийг бий болгох, капитал болгон хэрэглэж бараа таваараар солих арилжих, эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр ашиглаж иржээ. Энэ нь үйлдвэрлэлийн харилцаанд орох нөхцөлийг бүрдүүлэн баян хоосны ялгаа гарахад нөлөөлсөн байх магадлалтай. Таван зүйлийн тариатай холбогдох соёлыг нүүдлийн соёл иргэншлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж улирлын чанартай нь уялдуулан хавсарга аж ахуй хэмээн нэрлэж хэвшсэнийг залруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Таван зүйлийн тариатай холбогдох зан үйл, бэлгэдлийг утга соёлын хувьд шинжлэн үзвэл, дэлхий дахины соёлын голомтуудтай адил өсөн үржихүй, дахин амилахуйн, төрийн бэлгэдэл болдог монголчуудын өвөрмөц сэтгэлгээ ажиглагдаж байна. Учир нь бидний харьцуулан шинжилсэн археологийн олдворууд болон ахуйн хэрэглээнд таван зүйлийн тариаг ид шидтэй мэтээр сүсэглэн дээдэлж, “арван зүгтээ арвижин дэлгэрэхийн бэлгэдэл”, “дахин амилахуйн бэлгэдэл”, “өсөн үржихүйн бэлгэдэл”, “хойд насанд хоол хүнс болохуйн бэлгэдэл”, “мөнх оршихуйн бэлгэдэл” хэмээн хэрэглэсээр байгаа нь бидний хийсэн судалгаанаас тодорхой байна.

Эдгээр дүгнэлтүүдийг үндэслэн, таван зүйлийн тариатай холбоотой соёлын уламжлалыг монголчуудын үнэт зүйл, **өв соёл** юм хэмээн үзэх боломжтой.

### Ашигласан материалын жагсаалт

Сёбсиг, Сарангерел. 1986. *Mongyol tulyur bičig-ün čubural: Degedü Mongyol-un üliger domuy*. БНХАУ: Үндүсүтен-ү кеблел-үн qoriy-a (Үндэсний хэвлэлийн хороо).

Dorian Q. Fuller. 2011. *Pathways to Asian Civilizations: Tracing the Origins and Spread of Rice and Rice Cultures*.

Арьяасүрэн, Ч., Нямбуу, Х. 2023. *Монгол ёс заншлын их тайлбар толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Баярсайхан, Д. 2017. *Монголчууд дэлхийг эрхшээсэн морьтон дайчдын гүрэн (XII-XVII)*. Улаанбаатар: Мон судар хэвлэлийн газар.

Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ, Г. 2018. *Нийгэм-соёлын хүн судлалын онолын үүд*. Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар.

Буянчуулган, Б. 2018. *Монголын тариалангийн түүх*. Эрх. Урангуа, Ж. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Гонгоржав, Г. 2008. *Монголчуудын эрдэм ухааны уламжлал*. Улаанбаатар: Сутра



хэвлэлийн газар.

Дулам, С., Нандинбилиг, Г. 2007. *Монгол аман зохиолын онол I*. Улаанбаатар: МУИС.

Дулам, С., Нандинбилиг, Г., Дашдэжид, С. ба бус. 2021. *Монгол соёл иргэний судлал*. Улаанбаатар: МУИС Хэвлэлийн газар.

Дулам, С., 2018. *Бэлгэдэл зүйн судалгаа*. Улаанбаатар: СУИС. МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн

МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль. 2021. *Юань улсын судар*. Ред. Түвшинтөгс Б. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Очир, А., Мацүда, К., Эрдэнэболд, Л., Мүраока. ба бус. 2015. “Монголын эзэнт улсын Дундад Азид нэвтрэх түшиц хот Чингайг судалсан нь.” “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс” Хубилай сэцэн хааны 800 жилийн ойд зориулсан Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Ред. Цэрэндорж, Д. Улаанбаатар.

Плано Карпини. 1988. *Монголчуудын түүх*. Ред. Алтанцэцэг, Г. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Соёл урлагийн их сургууль. 2021. *Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл*. Ред. Сонинтогос, Э. Улаанбаатар: “Болор судар” хэвлэлийн үйлдвэр.

Сүхбаатар, Г. 2023. *Монголчуудын эртний өвөг. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*. Ред. Батсүрэн, Г. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Сэржээ Ж. 1990. *Монгол арвай*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн комбинат.

Төрбат, Д., Батсүх, Д., Баярхүү, Н. 2015. “Таван толгойн Монгол язгууртны булшнууд.” “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс” Хубилай сэцэн хааны 800 жилийн ойд зориулсан Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Ред. Цэрэндорж, Ц. Улаанбаатар.

Хао бүн шон, Доу цинчи. 1987. *Та илгээсэн Төвөд, Монгол хавсарсан мэдэгдэхүүнийг тийн тоо бүгдийг хураасан үгийн сан*. БНХАУ: Силингийн хэвлэлийн хороо.

Чулуунбаатар, Г. ба бус. 2020. *Монгол зан үйлийн нэвтэрхий толь. Оюуны боть*. Улаанбаатар: Соёмбо пресс хэвлэлийн газар.

ШУА, Түүхийн хүрээлэн. 2003. *Монгол улсын түүх. Тэргүүн боть*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Эрдэнэбат, У., Франкен, К., Батбаяр, Т. 2015. “Хархорумын Цогт их сүмийн гэр буюу Юань улсыг мандуулах асар.” “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс” Хубилай сэцэн хааны 800 жилийн ойд зориулсан Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Ред. Цэрэндорж, Ц. Улаанбаатар.